

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 02/277
дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн тайлан

/2024 оны жилийн эцсийн байдлаар /

1.2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 12 дугаар сарын 25-ны байдлаар иргэдээс 14 хүсэлт, 2 гомдол, 2 санал ирүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 8 гомдлоор бага байна.

Үзүүлэлт	2023.01.01 – 12.25		2024.01.01 – 12.25	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Хүсэлт	6	100%	14	100%
Гомдол	10	100%	2	100%
Санал	-	-	2	100%

2.2024.01.02-ноос 2024.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 14 хүсэлт, 2 гомдол, 2 саналыг хүлээн авч, удирдлага, холбогдох ажилтнуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр өргөдөл, гомдлыг ажлын 4 хоногт шийдвэрлэсэн. Үүнд:

1.О240220070 дугаартай хүсэлт: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн Адарсүрэн Намуун хиймэл болор суулгах мэс ажилбар хийлгэх болсон тул байгууллагаас дэмжлэг хүссэн, хүсэлтийг хүлээн авч, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяад шилжүүлэн, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6.16.6 дахь заалтыг үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц нэг удаагийн тэтгэмжийг байгууллагын даргын Б/03 дугаар тушаалаар олгож, хүсэлтийг иргэний талд бүрэн шийдвэрлэсэн.

2.О240220075 дугаартай хүсэлт: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Н.Өлзийжаргал нь хадам ээж болох Д.Хишигдорж нь насан өөд болсон тул байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу нэг удаагийн будалтгүй тусламж олгож өгнө үү гэсэн хүсэлтийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6.16.5 дахь заалтыг үндэслэн 300,000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгох байгууллагын даргын Б/02 дугаар тушаалаар тэтгэмж олгон хүсэлтийг иргэний талд бүрэн шийдвэрлэсэн.

3.Г240314047 дугаартай гомдол: Налайх дүүргийн 1-р хорооны иргэн А.Алтангэрэл нь Налайх дүүргийн 274 дүгээр цэцэрлэгийн багш байна. Бүх нийслэлийн цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулагддаг гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн 3 сарын 30-нд болох юм. Тус тэмцээний зохион байгуулах хороо буюу Нийслэлийн спортын хороонд нийслэлийн 9 дүүргийн тэмцээнд оролцож байгаа бүх цэцэрлэгийн багш нар гарын үсгээ зурж тэмцээний үзүүлэх үзүүлбэрээс "зохиомж" гэж төрлийг хасаж өгөх хүсэлт гаргасан юм.

Гэтэл Нийслэлийн спорт хорооноос хүсэлтийн хариуг өгөхгүй байсаар одоо тэмцээний удирдамж нь ирэхдээ "зохиомж" гэсэн тусдаа дасгал оролцуулахаар зааж ирсэн байна.

Гэтэл одоо хаврын улирал, хүүхдүүд ихээр ханиад томуу хүрч байгаа, дээрээс нь олон үзүүлбэр давтаж бэлдэн цээжлэх боломжгүй үед бага насны хүүхдүүдэд ийм ачаалал үүрүүлж болохгүй юм. Энэ асуудлыг шийдэж албан ёсоор хариу өгнө үү гэсэн гомдлын хүлээн авч Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс, Монголын Гимнастикийн холбоо тухайн өргөдлийн талаар Налайх дүүргийн 274 дүгээр цэцэрлэгийн багш Д.Баярмаа (түүний гар утасны 89040218)-тай өргөдлийн дагуу харилцан ярилцаж ойлголцсоны үндсэн дээр албан ёсны хариуг албан бичгээр түүний d.bayrmaa8888@gmail.com и-мэйл хаягаар илгээсэн. Боломжгүй тухай хариу өгсөн.

4.G0240322014 дугаартай хүсэлт: Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн спортын тэмцээн наадам, спортын холбоодын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд ажиллаж байсан бөгөөд хүүхэд харах чөлөөнөөс өөрийн хүсэлтээр 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн ажилдаа орох тухай Б.Солонгын хүсэлтийг хүлээн авч Байгууллагын даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар Б.Солонгыг ажилд эгүүлэн томилж хүсэлтийг иргэний талд шийдвэрлэсэн.

5.G240322136 дугаартай гомдол: Монголын гимнастикийн холбооны нарийн бичгийн дарга Г.Ерөөлтбат нь Хан-Уул дүүргийн цэцэрлэгийн хүүхдийн гимнастикийг товлосон хугацаандаа зохион байгуулахгүй байгаа тухай гомдол гаргасанд шийдвэрлэж хугацаанд зохион байгуулахаар болж иргэний талд шийдвэрлэсэн.

6.G240424055 дугаартай санал: Сонгинохайрхан дүүргийн 23-р хорооны иргэн С.Орхонбаяр нь Буянт-Ухаа спорт цогцолборт дугуйлан секц хичээллүүлэх санал гаргасанд "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ашиглалт болон үйл ажиллагааг ЗГТАТөрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандаж хүсэлтээ гаргах тухай 88109163 утсаар мэдээлэл өгч, боломжгүй тухай хариу өгч ажилласан.

7.G240426027 дугаартай санал: УБ, Баянзүрх, 1-р хороо, 79-12 тоотын иргэн Б.Цангиа нь Нийслэлд 12 магадлан итгэмжлэгдсэн бялдаржуулах төвүүдэд хяналт тавьж ажиллуулах тухай саналыг ЗГТА-Биеийн тамир, спортын улсын хороо үндсэн үйл ажиллагаа тул тус газарт хандах тухай мэдээлэл өгсөн бөгөөд хүлээх авах боломжгүй тухай хариу өгсөн.

8.C240430029 дугаартай гомдол: Баянгол дүүргийн 5-р хорооны иргэн А.Энхтамираас ахлах насны эмэгтэй шигшээ тоглолтыг үлдээж нэг хүүхэд өөр тэмцээнд орж байгаа нэрийдлээр тэмцээний хойшлуулж байгаад гомдол гаргасанд 88108372 утсаар боломжгүй тухай хариу өгсөн.

9.O240806099 дугаартай санал: Мэргэжилтэн Б.Солонго нь ажлын байр Яармаг дахь Хангарди ордон руу нүүсэнтэй холбоотойгоор хүүхэд асрах чөлөөг үргэлжлүүлэн эдлэх тухай хүсэлтийг хүлээн авч байгууллагын даргын Б/12 дугаар тушаалаар хүүхэд асрах чөлөөг үргэлжлүүлэн олгож иргэний талд шийдвэрлэв.

10.O240828141 дугаартай санал: Нягтлан П.Ариунцэцэг нь БНСУ-д мэргэжил дээшлүүлэх болсон тул сургалтын төлбөрт дэмжлэг хүссэнд Байгууллагын даргын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар П.Ариунцэцэгийн сургалтын төлбөрт 1 сая төгрөгийн тэтгэмж шийдвэрлүүлж иргэний талд шийдвэрлэсэн.

11.О240830049 дугаартай санал: Ганболд овогтой Ууганжаргал нь БЗД-ийн БТСХороонд ажилладаг бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нийслэлийн Биеийн тамир, спортын газар шилжин ажиллах хүсэлт гаргасанд байгууллагын даргын Б/14 дүгээр тушаалаар Спортын тэмцээн наадам, спортын холбоод хариуцсан мэргэжилтний албан тушаалд Г.Ууганжаргалыг түр орлон гүйцэтгэгчээр томилон иргэний талд шийдвэрлэв.

12.О240830093 дугаартай санал: Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн А.Намуун нь эрүүл мэндийн шалтгаанаар төрийн албанаас түр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул А.Намууныг байгууллагын даргын Б/13 дугаар тушаалаар 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн төрийн албанаас түр чөлөөлөв.

13.О240903179 дугаартай санал: Баянзүрх, 25-р хороо, 66-57 хаягтай Баянзүрх дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэст мэргэжилтнээр ажиллаж байсан Н.Сүнжидмаа нь манай байгууллагаас зарлагдсан сул орон тооны захиалгын дагуу шилжин ажиллах хүсэл гаргасныг шийдвэрлэн байгууллагын даргын Б/15 дугаар тушаалаар Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилж иргэний талд шийдвэрлэв.

14.О240913078 дугаартай хүсэлт: Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэ Удирдлагын академийн ахлах түшмэлийн багц сургалтад суух болзол хангасан тул байгууллагаас сургалтын төлбөр болох 1,620,000 төгрөгийг шийдвэрлэж, суралцах нөхцөл боломжийг хангаж өгнө үү гэж хүсэлт гаргасныг 2024 оны сургалтын зардал төсөв байхгүй тухай өөрт танилцуулсан бөгөөд 2025 оны сургалтын зардалд тус сургалтын зардлыг тусгуулж, 2025 оны 03 дугаар сарын ээлжид сургалтад хамрагдах тухай өөрт мэдэгдсэн.

15.О240920252 дугаартай хүсэлт: Сүхбаатар, 10-р хороо, 24-26 тоот хаягтай А.Отгончимэг нь Усан спорт сургалтын төвийг 2021 онд засвар хийхээр хааснаас хойш одоо болтол 3 жил ашиглалтад оруулахгүй байгаад сэтгэл дундуур байна. Менежментийн хувьчлал нэрээр Этүгэн их сургууль авч төвийн жижиг бассейн болон фитнесийг хааж сургалтын зориулалтаар ашигласан. Гэтэл үндсэн том бассейныг эхэн үедээ усанд орох хэсгийг зассанаас өөр засвар оруулахгүй байсаар 2021 оны 10 дугаар сараас засвар хийхээр хаасан ч одоо болтол ашиглалтад оруулахгүй байгааг шалгаж хэзээ ашиглалтад оруулах тухай хариуг өгнө үү гэж хүсэлт гаргасныг “Этүгэн” их сургуулийн захирал Хишигбаяраас тодруулга тайлбарыг утас /99023329/-аар холбогдон авсан бол тус усан бассейны засварын ажлын явцын танилцуулгыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын цахим хуудсаар авч 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр иргэн А.Отгончимэгт тус усан бассейнд иж бүрэн засвар хийгдэж байгаа бөгөөд 2024 онд багтаан дуусгаж хэвийн үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байгаа тухай тайлбар мэдээллийг өгч гаргасан хүсэлтийг нь шийдвэрлэв.

16. О240903179 дугаартай хүсэлт: Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгын дагуу Н.Сүнжидмаа шилжин ажиллах хүсэл гаргасны дагуу байгууллагын даргын Б/15 дугаар тушаалаар Н.Сүнжидмааг албан тушаалд томилон иргэний талд шийдвэрлэсэн.

17. О241105165 дугаартай хүсэлт: Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан Н.Сүнжидмаа нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл урлагийн газарт төлөвлөгөө тайлан, дотоод ажил хариуцсан мэргэжилтнээр шилжин ажиллах хүсэлттэй байгаа тул шийдвэрлэж өгнө үү гэсэн хүсэлтийг он дуустал шилжүүлэх

боломжгүй тухай мэдэгдэж, 2024 оны байгууллагын тайлан тооцоог дуусгавар болгож ажлаас чөлөөлөх тухай шийдвэр гаргалаа.

18. О241205100 дугаартай хүсэлт: Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан Н.Сүнжидмаа нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг 2024 оны байгууллагын тайлан тооцоог дуусгавар болгож ажлаас чөлөөлөх тухай шийдвэр гаргалаа.

3.2024.01.02-ноос 2024.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 14 хүсэлт, 2 гомдол, 2 саналыг шийдвэрлэхдээ явцын тэмдэглэлийг тус бүрд 1 удаа хөтлөн явуулсан.

4.Өргөдөл гомдлын индексийн үнэлгээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 0,87 хувь байсан бол 2024.01.02-ноос 2024.12.25-ны хооронд 0,86 хувийн индекстэй байна.

5.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2023 оны жилийн эцсийн байдлаар 4 хоног 17 цаг 57 минут байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 4 хоног, 20 цаг 32 минут байна.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.Оюунтуяа

Б.ОЮУНТУЯА



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
 02/277 дугаар албан бичгийн
 хоёрдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
 ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ
 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 26

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажлын нэр	2024 оны жилийн эцсийн байдлаар		
		Одоогийн байдал	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн
1.	Өргөдөл гомдлын индексийн үзүүлэлтийг дээшлүүлэхэд тухай бүр анхаарч ажиллах	2024.01.02-ноос 2024.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 14 хүсэлт, 2 гомдол, 2 саналын индекс 0,86 болсон.	Байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлын индексийг дээшлүүлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээллийг байгууллагын удирдлага, албан хаагчдад 14 хоногт 1 удаа танилцуулах;	Байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчдад 14 хоног тутам байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандсан хүсэлт, өргөдөл гомдол байхгүй талаар мэдээлсэн.
2.	Иргэдээс гаргаж буй өргөдөл, гомдлын шалтгаан нөхцөлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагчийн түвшинд нарийвчлан судалж, өргөдөл гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишиг тогтоож ажиллах	Тайлант хугацаанд албан тушаалтанд хандаж Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт иргэдээс гаргаж буй өргөдөл, гомдлын шалтгаан нөхцөлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагчийн түвшинд нарийвчлан судалж, өргөдөл гомдлыг хууль зүйн үндэслэлтэй нийт ирсэн 18 өргөдлийг шийдвэрлэхэд боломжгүй тухай хариу	Байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлүүлэхийн тулд тухайн өргөдөл гомдлын шалтгааныг олж, холбогдох албан тушаалтан, мэргэжилтэнд шилжүүлэн, 14 хоног тутам удирдлагад мэдээлж, өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд хууль зүйн үндэслэлийг сайтар гаргаж, өргөдлийн хариуг тухайн иргэнд хугацаанд нь өгч, шийдвэрлэлтийг программд хоцроолгүй оруулах, хуулийн дагуу шийдвэрлэх;	Ирүүлсэн өргөдөл гомдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох ажилтанд шилжүүлж, 14 хоног тутам удирдлагад танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, шийдвэрлүүлснээр тухайн өргөдөл гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишиг тогтоно.

		өгсөн 7, иргэний талд шийдвэрлэсэн 11 өргөдөл байна.		
3.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах	2024.01.02-ноос 2024.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 14 санал, 2 хүсэлт, 2 гомдлыг хүлээж авч, удирдлага, холбогдох ажилтнуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр өргөдөл, гомдлыг ажлын 4 хоногт шийдвэрлэсэн.	Өргөдөл, гомдлын программыг өдөрт 2 удаа тогтмол шалгаж, ирүүлсэн өргөдлийг өдөрт нь шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутам байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 5 хоногт багтаан барих;	Өргөдөл, гомдлын программыг өдөрт 2 удаа тогтмол шалгаж, ирүүлсэн өргөдлийг өдөрт нь удирдлага, холбогдох ажилтнуудад шилжүүлж, шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног бүр байгууллагын удирдлагад танилцуулж, мэдээлэл хийснээр өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нийслэлийн дундаж хугацаанд 5 хоногт шийдвэрлэнэ.
4.	Иргэдээс гаргасан саналын шинжтэй өргөдлийг байгууллагын үйл ажиллагаанд тусгаж, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлан мэдээнд тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулж хэвших	Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2024 оны жилийн эцсийн тайланг цахим хуудсандаа байршуулахаар бэлтгэж байна.	Байгууллагад иргэдээс саналын шинжтэй өргөдөл ирүүлсэн тохиолдолд үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлсэн биеийн тамир, спортын аливаа арга хэмжээг тайлан мэдээндээ тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон пэйж хуудсандаа ил тод, нээлттэй байршуулж ажиллах;	Байгууллагад иргэдээс ирүүлсэн саналын шинжтэй өргөдөл шийдвэрлэж, олон нийтэд ил тод болгоно.
5.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөх	2024.01.02-ноос 2024.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 14 хүсэлт, 2 санал, 2 гомдлыг шийдвэрлэхдээ явцын тэмдэглэлийг тус бүрт 1 удаа хөтлөн явуулсан.	Байгууллагын удирдлага, ажилтнуудад өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцдаа явцын тэмдэглэлийг хөтөлж байхыг зөвлөх, хяналт тавих, 14 хоног тутмын мэдээ гаргах, алдаа дутагдал, зөрчил гаргахгүй ажиллах;	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад явцын мэдээлэл тухайн иргэнд нээлттэй болж, явцын тэмдэглэл хөтөлж, шийдвэрлэлтийн индексийн үзүүлэлт дээшилнэ.

6.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан мэдээний боловсруулалтад анхаарч ажиллах	2024.01.02-ноос 2024.12.25-ны хооронд иргэдээс ирүүлсэн 14 хүсэлт, 2 санал, 2 гомдлын шийдвэрлэлийн мэдээг шаардлагын дагуу гаргаж хүргүүлсэн.	Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан мэдээг гаргахдаа өргөдөл гомдлын шалтгаан, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, байгууллагын цахим хуудас болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн зэргийг тусгаж ажиллах.	Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан мэдээнд иргэдээс ирүүлсэн саналын дагуу хийж хэрэгжүүлсэн, зохион байгуулсан арга хэмжээний тайлан, тоон үзүүлэлтийг бүрэн оруулсан байна.
----	-----------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

[Signature]



С.САРАНЦЭЦЭГ

М.ЦОГЗОЛМАА

Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02/027
 дугаар албан бичгийн гуравдугаар хавсралт



Нийслэлийн Биеийн тамир, спортын газар
 Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

(2024 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар)

2024/01/02 – 2024/06/25

№	Өргөдөл гомдлын агуулга	Нийт тоо	Хэлбэр						Агуулга				Шийдвэрлэж хариу өгсөн			Шийдвэрлэж байгаа	
			Амаар	Бичгээр	Утсаар	11-11 төвөөс	1800-1200 утаснаас	Дээд байгууллагаас ирсэн	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа хэтэрч хариу	Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
1	Цахим програмд бүртгэгдсэн	18	0	9	0	5	1	0	0	2	14	2	18	0	0	0	0
2	Цахим програмд бүртгэгдээгүй	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
ДҮН:		18	0	9	0	5	1	0	0	2	14	2	18	0	0	0	0

ТАНИЛЦСАН:
 НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
 ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
 ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН




С.САРАНЦЭЦЭГ

М.ЦОГЗОЛМАА

(Handwritten signature)

Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/2024
дугаар албан бичгийн дөрөвдүгээр хавсралт



**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАРТ
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

/2024 жилийн эцсийн байдлаар/

2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлт холбогдох хууль, дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж, ажлын үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, үйл ажиллагааг сайжруулах талаар санал, зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэх зорилгоор дүн шинжилгээ хийв.

НБТСГ-ын өргөдөл, гомдлыг хүлээн авах хэлбэр:

Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл гомдлыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүртгэл, Засгийн газрын "11-11 төв"-ийн оператор, 1800-1200 дугаарын оператор зэрэг хэлбэрээр хүлээн авч байна.

Хүлээн авсан өргөдөл гомдол:

2024 оны 01 дүгээр сарын 02-ноос 12 дугаар сарын 25-ны байдлаар иргэдээс хүсэлт-14, гомдол-2, санал-2, нийт 18 өргөдөл ирүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 8 гомдлоор бага байна.

Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	2023.01.01 – 12.25		2024.01.02 – 12.25	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Хүсэлт	6	100%	14	100%
Гомдол	10	100%	2	100%
Санал	-	-	2	100%

Өргөдөл, гомдлын хандалтын тайлан

Хүснэгтээр харуулбал:

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Биеийн тамир, спортын арга хэмжээний тухай	4	22.22%
2	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	3	16.67%
3	Ажилд орох тухай	3	16.67%
4	Ажлаас чөлөөлөгдөх тухай	1	5.56%
5	Жирэмсний амралтын тухай	1	5.56%
6	Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны тухай	1	5.56%
7	Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны үйл ажиллагааны тухай	1	5.56%
8	Шагнал, урамшууллын тухай	1	5.56%
9	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	1	5.56%

10	Фитнес, бялдаржуулах төвүүдийн үйл ажиллагааны тухай	1	5.56%
11	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын шийдвэрлэх эрх хэмжээний бус асуудлын тухай	1	5.56%
Нийт өргөдөл, гомдлын дүн		18	100.00%

Тайлант хугацаанд иргэдээс байгууллага, албан тушаалтанд хандаж 14 хүсэлт, 2 гомдол, 2 санал ирүүлснийг өдөрт нь хүлээн авч, шийдвэрлэлтийн дундаж хугацааг 4 хоног 20 цаг 32 минут болсон. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн индекс 0,86 болж буурсан.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2024 оны жилийн эцсийн байдлаар биелэлтийг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд албан тоотоор тайлагнаж, гаргасан тайлан мэдээг байгууллагын www.sport.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



М.ЦОГЗОЛМАА

B.Oyuntuuya

Б.ОЮУНТУЯА